


УЛААН МАНЖИН

Ач холбогдол.

	Бие махбодод тохиромжтой харьцаа бүхий фосфор, кали , аскорбины хүчил иодоор хамгийн баялаг хүнсний ногоо юм. Цусны даралт бууруулах, хорт хавдраас урчилан сэргийлэхэд эмчилгээний зориулалтаар хэрэглэнэ
---	--

Сорт. Бордо-237. Энэ сортын манжин бөөрөнхий хэлбэрийн бүдэг ягаан өнгөтэй. 76-83 хоногт ургаж гүйцдэг. Үр нь арзгар хэлбэртэй, цайвар хүрэн өнгөтэй, хам жимстэй.



Ургах нөхцөл. Үр нь +8°C-д соёолж эхлэнэ. 10-12°C-д эрчимтэй ургана. Чийгний илүүдэлд тэсвэр муутай гэрэлд дуртай ургамал. Хэрэв гэрэл дутагдвал ургац буурах төдийгүй чанар нь муудна. Ялзмаг ихтэй шим тэжээл сайтай хөнгөн шавранцар ба элсэнцэр хөрсөнд сайн ургана.

Хөрс боловсруулалт. Хавар цэнэг усалгааны дараа хөрсний үржил шимээс хамааран 1 м. кв 4-9 кг бүрэн ялзарсан бууц хийж жигд тараагаад эргүүлж хагална. Цэнэг усалгаа гэдэг нь хавар тариалалтын өмнө хөрсийг 40-50 см гүн нортол услахыг хэлнэ. Энэ усалгаа нь хөрсөнд суулгасан үрийг соёолж гарч иртэл ус чийгээр цэнэглэж байх үүрэгтэй.





Ээлжлэн тариалалт.






Тарилт. Улаан манжинг үрээр болон үрслэгээр тарьж болдог

	Говийн бүсэд үрээр таривал 5-р сарын 1-нээс 5-р сарын 15-ны хооронд эгнээ хооронд 20-25 см зайтай ургамал хооронд 15 см зайтайгаар үрийг 2-3 см гүнд суулгана
	Үрслэгээр таривал IV/10-IV/25 хооронд дарлага ба хучлагатай хөрсөнд үрийг суулгаж, үрслэг ургуулаад VI сарын эхний 10 хоногт 4-5 навчтай болсон үед эгнээ хооронд 25см ургамал хооронд 15см зайтай суулгана . Үрслэгийг шилжүүлэн суулгасаны дараа сайтар услана.

Арчилгаа Чийгэнд дуртай боловч чийгийн илүүдлийг тэсвэрлэхдээ муу. Энэ нь хөрсний агаарын дутагдалыг тэсвэрлэж чаддаггүйтэй холбоотой. Хөрсөнд агаар дутагдсан нөхцөлд навчны гадаргуу нь нэлэнхүйдээ улаан туяа татаж ургалт нь зогсдог. Иймд усалгаа бүрийн дараа хөрсийг сийрүүлнэ.

	Улаан манжинг тарихын өмнө цэнэг усалгаа (1 м ² талбайд 40л усаар) сайн хийж өгсөн тохиолдолд соёолж гарч иртэл услахгүй ба анхны навч гарч ирсэний дараа 1 м ² талбайд 20-25л усаар услана
	Усалгаа бүрийн дараа мөр хооронд сийрүүлнэ. Энэ нь хог ургамал устгах, хөрсний агааржилтыг сайжруулах, үндэс үрийг томруулах, хөрсний чийгийн алдагдлыг багасгах, усалгаагаар өгсөн ус ба хур борооны усны ашиглалтыг сайжруулах зэрэг ач холбогдолтой.
	2 дахь усалгаанаас эхлэн нэмэлт бордоо хэрэглэх ба үүнд бууц ба шувууны сангасны шингэнийг ашиглана. Үүнийг бэлтгэхдээ 100л усанд 20кг бууц ба сангас хийж 3-7 хоног эсгээд түүнийгээ 10 дахин шингэлж бордсоны дараа шууд услана.
	2-3 навч гарч ирсэн үед нь хам жимснээс гарч ирсэн ургамлаас сайн ургасныг үлдээж бусдыг сугалан авч цөөлнө. Хам жимс гэдэг нь харахад нэг үр боловч дотроо олон ургах нахиатай байдаг. Ийм үрийг тариахад нэг үрнээс олон соёо ургадаг.

Хураалт, хадгалалт: IX сарын дундуур хурааж эхлэх ба хураахаас 7-14 хоногийн өмнө усалгаа хийж өгөх нь хадгалалтын чанарыг сайжруулдаг.

	Хальс нь нимгэн учир гэмтээхээс болгоомжилж хураахаас өмнө хөрсийг сайн суллана
	Хурааж авсаны дараа хатааж, зоорилж хадгалж болно. Зоорилж хадгалах бол ишийг 2-3 см үлдээж тайрна.
	0-1°-д хэмийн нөхцөлтэй 90-96%-ийн харьцангуй чийгтэй зооринд хайрцганд ба задгайгаар элсэлж хадгална.

Хүрэн манжингийн салат. 1кг төмсгийг 0,8 см хэмжээтэйгээр шоо дөрвөлжин хэрчиж чанаад хүйтэн усанд сойж тавина. Дараа нь хүрэн манжинг хальстай нь 5 минут чанаж хальслаад мөн 0,8 см хэмжээтэй шоо дөрвөлжин хирчэнэ. Түүн дээрээ чанаж бэлэн болгосон төмсөө бага зэрэг хэмх, сонгино давс, хиамтай хольж хийгээд ургамлын тосоор хутгана.

Хүрэн манжинг даршлах. 0,5 кг хүрэн манжинг хальстай нь 5 минут чанаад хальсЛаж үрүүрээр үрнэ. Дээрээс нь 2-3 ширхэг саримсыг мөн үрж хийгээд давс бага зэрэг хийж ургамлын тосоор хутгаж хэрэглэнэ. Удаан хадгалах бол ариутгасан шилэнд бэлэн болсон бүтээгдэхүүнээ хийж сул таглаад 15 минут чанаж гаргангуут тагийг чангалж доош харуулж хөргөөд сэрүүн газар хадгална.